

МОНГОЛ ДАХЬ ХАМТРАЛЖУУЛАЛТ БА ЗХУ-ЫН  
НӨЛӨӨЛЛИЙГ ЭРГЭН ХАРАХ НЬ

Р.ТӨРДАЛАЙ

**Товч агуулга:** Энэхүү өгүүлэлд нэгдэлжих хөдөлгөөний эхлэл цэг болж, түүхнээ ухаарал, сургамжийг хослуулан үлдээсэн 1930-аад оны Монголын хөдөө аж ахуйн хөгжилд Зөвлөлт Оросын үзүүлсэн бодит нөлөөллийг архивын баримтад түшин залгамж холбоонд нь тусган авч үзэхийг зорилоо. Ингэснээр хамтралжуулалт нь үнэн хэрэгтээ Монголын эдийн засгийн түүхэнд дэх “зөвлөлтжүүлэх бодлого”-ын үр хөврөл байсан эсэх талаарх судлаачийн байр суурийг илэрхийлэхийг чухалчилсан болно. Өөрөөр хэлбэл уг асуудлыг голчлон Зөвлөлт Орос улсын байр суурь, улс төрийн бодлогын нөлөөлөлтэй холбон тайлбарлаж ирсэн өмнөх концепцийг эргэн харах болно. Мөн тус өгүүлэлд Монголын талын хэт хувьсгалжилт, гажуудал хийгээд Зөвлөлт Орос улсаас БНМАУ дахь эдийн засгийн хөгжлийн үйл явц, ялангуяа хамтралжуулалтын асуудлаар төдий л идэвхтэй бус байр суурь баримталж байсныг тодотгох, энэ хүрээний зангилаа асуудлын уулзвар дээр бодит байдлыг зураглахад гол анхаарлаа хандуулав.

**Түлхүүр үг:** БНМАУ, хамтралжуулал, бодит байдал, хувьсгалжилт, Зөвлөлт Орос улс, нөлөөлөл, үнэлгээ

**Keywords:** MPR, collectivization, reality, revolution, Soviet Russia, influence, evaluation

**Удиртгал**

Олон мянганы туршид дөрвөн цагийн аясаар нүүдэллэн амьдарч салангид, амиа аргацаасан байдлаар аж ахуйгаа хөтлөн явуулж ирсэн малчдыг амьдралынх нь уламжлалт тогтсон байдлаас гаргаж, хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орны хөдөлмөрчин иргэд болгон өөрчлөхөд нэгдэлжих үйл явц түүхэн нөлөөгөө үзүүлсэн билээ. Энэ талаар тухайн үеийн нам төрийн удирдлагаас “Ардын аж ахуйтныг нийгмийн социалист аж ахуйн замд бүрэн оруулсан явдал бол 1921 оны Ардын хувьсгалтай эн зэрэгцэх ач холбогдол бүхий түүхэн үйл явдал” хэмээн онцгойлон үнэлж байв.<sup>1</sup>

<sup>1</sup> Цэдэнбал, Ю. *Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг*, II боть, Улаанбаатар, 1967, 421.

Гэвч хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орны хөдөлмөрчин иргэн болох замнал шулуун дардан байсангүй. Монгол малчдын дунд хөдөлмөрөө хорших үзэгдэл түүхийн туршид уламжлагдаж ирсэн боловч төрөөс зохион байгуулалттайгаар өрнүүлж, үзэл сурталжуулсан анхны тохиолдол нь хамтралжуулах бодлого байлаа. Иймд улсаас мал аж ахуйг нийгэмчлэх талаар авч хэрэгжүүлсэн анхны оролдлого болох хамтралжуулалт нь төрийн албадлага, хүчирхийллийг хэрэглэх замаар хувийн өмчийг түүхэндээ анх удаа устган улс, хоршооллын өмч бүхий нийгмийн бүтцийг буй болгохыг зорьсноор малчдын үе дамжин хуримтлуулсан өмч, баялаг болох мал сүргийг эзэнгүйдүүлэн хоосруулж, ард түмний дунд урт хугацаанд хамтын аж ахуйн талаар нэн таагүй дурсамж, уур амьсгалыг үлдээсэн хохирол, сүйтгэлийн эмгэнэлт он жилүүд болсон юм.

БНМАУ-ын төр энэхүү бодлогын алдаа руу хэрхэн гулсан орсон хийгээд түүний онол, үзэл санааны суурь нөлөөллийг энэхүү өгүүллийн хүрээнд судлан үзэв. Энэ нь хожмын нэгдэлжих болон нэгдлийн эрин үеийн суурь асуудлын олон ээдрээ зангилааг тайлбарлахад чухал ач холбогдолтой хэмээн бид үзсэн болно.

### **В.И.Лениний Империализмын онол ба Хоршоолох үйл явц**

К.Маркс, Ф.Энгельс нарын суурийг нь тавьж, В.И.Лениний нэмэлт хийж боловсруулсан Империализмын онолд колони болон хагас колони хоцрогдсон орнууд капиталист биш замаар хөгжихөд капитализмын өмнөх харилцаа нь социализмд шилжихэд саад болж чадахгүй бөгөөд тэргүүний орны пролетарийн тусламжтайгаар хоцрогдсон орнууд капиталист шатны хөгжлийг алгасан зөвлөлт байгуулалд, мөн хөгжлийн тодорхой шатыг дамжиж коммунизмд хүрч чадна”<sup>2</sup> гэж үзэж байсан нь уг үзэл санааг хожим Зөвлөлт орноор төдийгүй дэлхийн тэн хагаст, тодруулбал Монгол оронд ч нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн билээ. Дээрх онолын дагуу хоцрогдсон улс орнуудад дараах түүхэн нөхцөл бүрдсэн үед капитализмыг алгасан социализмд хүрч болох тухай номлосон байдаг. Үүнд:

1. Нийгмийн капиталист харилцаа хөгжсөн тэргүүний орнуудад эхлээд социалист хувьсгал ялж, пролетарийн диктатур тогтсон байх;
2. Капиталист харилцааны өмнөх феодализм, боолчлол, хүй нэгдлийн харилцааны үлдэгдэл ноёрхсон хоцрогдмол улс орнуудад хөрөнгөтний өмнөх үйлдвэрлэлийн аргын эсрэг ардчилсан эсвэл тариачны хувьсгал ялсан байх;

<sup>2</sup> Ленин, В.И. *Түүвэр зохиол*, 31 дүгээр боть, 230.

3. Энэ хоёр хувьсгал бие биедээ харилцан нөлөөлж, нэг нь нөгөөгөө шууд дэмжин бүх талаар туслах зэргийг тодорхойлон заасан байна.<sup>3</sup>

Лениний “Империализмын онол”-д хоршооллын талаарх үзэл баримтлалыг К.Маркс, Ф.Энгельс нарын боловсруулсан Түүхийн материализмд тулгуурлан авч үзэж, үйлдвэрлэлийн хэрэгслийг нийгэмчилж чадаагүй нөхцөлд хоршоолох үйл явцад бүрэн утгаар амжилттай хэрэгжиж чадахгүй тухай бичиж байв.<sup>4</sup>

В.И.Ленин дээрх үзэл санаанд тулгуурлан өөрийн онолоо хөгжүүлж, дээрх асуудалд холбогдох “Тосгон дахь ажил”, “Газрын тухай илтгэл” бүтээлдээ өөрийн байр сууриа тодорхой тусган улмаар хоршооллын үзэл санаагаараа дамжуулан хөдөөд социализм байгуулах арга замыг боловсруулсан байна. Харин хожмын эрдэмтэд К.Марксын нийгмийн хөгжлийн сургаалыг санаатайгаар гажуудуулснаар<sup>5</sup> хожим В.И.Лениний дараа үеэс “социалист нийгэм байгуулах тухай” идэвхтэй ярих болж, ингэхдээ улс, хоршооллын өмч давамгайлсан нийгэм байгуулах зорилго тавьсан нөхцөлд түүнд саад тотгор болох бүхнийг хүч хэрэглэн устгахыг зөвтгөн албадлага, хүчирхийллийн арга хэрэглэхийг зааж байв. В.И.Лениний “Империализмын онол”-оос эхтэй дээрх үзэл санааны үр хаялга ийнхүү БНМАУ-д хамтралжуулалт нэрээр хоршооллын эх үндсийг тавьсан байна.

В.И.Ленин дээрх онолын үндэслэлээ “Бүх үндэстэн социализмд орох нь зайлшгүй боловч цөмөөрөө харилцан адилгүй байдлаар орох бөгөөд үндэстэн тус бүр ардчиллын ямар нэг хэлбэр, пролетарийн диктатурын ямар нэг байдал, нийгмийн амьдралын янз бүрийн талыг социалист ёсоор өөрчлөх ажлын явцад өвөрмөц байдлаа тусган оруулна”<sup>6</sup> гэж тайлбарлаж байлаа. Өөрөөр хэлбэл, хөрөнгөтний болон түүний өмнөх нийгмээс капиталист биш хөгжлийн замаар социалист нийгэмд орох нийгэм-эдийн засгийн агуулга ямар ч оронд хэзээд нэг байдаг боловч орон орны түүхэн тодорхой нөхцөл, үндэсний онцлог, ялангуяа соёл, шинжлэх ухаан, эдийн засаг, үйлдвэрлэлийн хүрсэн түвшин, нийгмийн харилцааны янз бүрийн хэв маягаас хамааран социалист нийгэмд шилжих цаг хугацаа, арга зам, хурдац, хэлбэр нь харилцан адилгүй байхыг В.И.Ленин онолын талаар нотлохыг оролдож байжээ.<sup>7</sup>

<sup>3</sup> Маркс, К., Энгельс, Ф. *Түүвэр зохиол*, 2 дугаар боть, Улаанбаатар, 1970, 449-475.

<sup>4</sup> Маркс, К., Энгельс, Ф. Соч Т-27, 681.

<sup>5</sup> Ядамсүрэн, Ж. *Капиталист биш хөгжлийн замын тухай онол, Монголд судлагдсан байдал*, Редактор Б.Даш-Ёндон, Улаанбаатар: Сэлэнгэпресс, 2012, 18-20.

<sup>6</sup> Ленин, В.И. *Түүвэр зохиолууд*, 23 дугаар боть, 65.

<sup>7</sup> Ядамсүрэн, Ж. *Капиталист биш хөгжлийн замын тухай онол, Монголд судлагдсан байдал*, Редактор Б.Даш-Ёндон, Улаанбаатар: Сэлэнгэпресс, 2012, 26-27.

Гэвч В.И.Ленин өөрийн онолоо биечлэн хэрэгжүүлж чадаагүй тул 1920-иод оны дунд үеэс түүний онолд хувьсгалч “тодотгол” илүүтэй тусч 1920-иод оны сүүлээр ЗХУ-д нийгмийн чинээлэг хэсгийн хөрөнгийг хурааж, бүх тариачдыг хамтралд оруулан үйлдвэрлэлийн хэрэгслийг нийгэмчилж, хөдөлмөрөө хоршин амьдрах аргыг нэвтрүүлжээ. Хоршоолол бол тариачдыг социализмд хөтлөх хамгийн хялбар, ойлгомжтой, хүртээмжтэй зам мөн гэсэн В.И.Лениний үзэл санааг сууриа болгон түүнийг нас барсны дараа И.В.Сталин хоршоолохыг яаравчлан шахаж, “1929-Агуу их эргэлтийн он” олонх тариачдын сэтгэл санаа энэ үед хамтралжих зүг рүү эрс эргэсэн мэтээр хийсвэр дүгнэлт хийх болжээ. Гэтэл үнэн хэрэгтээ В.И.Ленин “Империализмын онол”-ын талаарх өөрийн үзэл баримтлалаа амьдралынхаа сүүлийн жилүүдэд эргэн харж, зарчмын нэлээд өөрчлөлт оруулахыг эрмэлзэж байсан ч харамсалтай нь амжаагүй байна.<sup>8</sup>

Хамтралуудыг үй олноор кампаничлан байгуулах дээрх үйл явц дан ганц Монгол оронд явагдаагүй бөгөөд Зөвлөлт оронд ч дээрх мэт алдаа нугалаа ихээхэн гарсаар байжээ. Хэрвээ 1920-иод оны дунд үед В.И.Ленин онол, үзэл баримтлалдаа тодотгол шинэтгэл хийж амжаад амьдрал дээр гүйцээн хэрэгжүүлсэн бол түүхэн үйл явцын өрнөл, Орос орны цаашдын хувь заяа өнөөдрийнхөөс арай өөр байж болох байсан гэдэг санааг эрдэмтэд судалгаандаа дэвшүүлсэн нь бий.<sup>9</sup>

Коминтерний онолчдын үзэж байснаар коммунизм байгуулах зорилт Төв Азийн орнуудад, тэр дундаа Монголд ч нэгэн адил явагдах учиртай байв. Үүний учир шалтгаан нь ЗХУ-ын Алс Дорнод, цаашлаад Ази тив рүү хандсан үзэл суртлын нөлөөний хүрээгээ тэлэх улс төрийн ашиг сонирхлын хүрээнд Монгол орон чухал түшиг газар болж байсантай холбоотой юм. Үүний тулд БНМАУ-д хувьсгалт үзэл санаагаа нутагшуулах, түүнд хамгийн их саад тогтор болж байсан Монголын нийгмийн оюундаг болон хөрөнгөлөг хэсгийг устгах эдийн засгийн хөшүүрэг хэлбэрээр энэхүү улс төрийн бодлогоо хэрэгжүүлжээ. Өөрөөр хэлбэл, ЗХУ-ын энэ үед Монголд явуулсан эдийн засгийн хүрээний шинэчлэл хэмээн үзэж байсан хувийн өмчийг устгах, хоршоолол, улс нийтийн өмч бүхий салбарласан тогтолцоог буй болгох, нийгмийн дээд давхаргын газар эзэмшлийн эрхийг хязгаарлах зорилтууд нь Монгол орныг хөгжүүлэх зорилт тавихаас илүүтэйгээр Лениний империализмын онолд туссанчлан улс төрийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд эдийн засгийн нөлөөллийг хөшүүрэг болгон хэрэглэсэн үзэгдэл байсан билээ.

<sup>8</sup> Siegfried Schieder, Manuela Spindler (Hrsg.) *Theorien der Internationalen Beziehungen*, 3. Auflage, “Lenin Imperialismustheorie”, Verlag Barbara Budrich, 2010, 321-325.

<sup>9</sup> Чулуунбаатар, Л. “Түүхэн үйл явцын их масштабын шатлал ба Иргэншлийн онол”, *Түүхийн судалгааны онол-арга зүйн асуудал*, Улаанбаатар, 1999, 99.

Үүний тулд Монгол орны бүх хошуудаар хүн ам, мал хөрөнгийн дэлгэрэнгүй судалгаа, тооллого бүртгэл явуулж, нийгмийн дээд давхаргын хүн ам, мал хөрөнгө, газар нутгийн байршлыг нэг бүрчлэн бүртгэж авчээ.<sup>10</sup> Хожим тэрхүү бүртгэл судалгаандаа үндэслэн 1930-аад оны эхнээс язгууртнууд, баячуудын өмч хөрөнгө, мал сүргийг нь улсад хураан авах кампанит ажлыг өрнүүлсэн байна.

### **1930-аад оны Монгол орны мал аж ахуйн байдал**

Архивт хадгалагдаж буй энэ тооллогын эх сурвалжаас гадна Зөвлөлтийн эрдэмтэн М.И.Майскийн 1921 онд Эрхүү хотноо хэвлүүлсэн Современная Монголия<sup>11</sup> бүтээлд Автономит Монголын 1918 оны хүн ам, мал сүргийн тооллогын статистик үзүүлэлт болон тэр үеийн монголчуудын нийгмийн байдалтай холбоотой судалгааны тайлан, ажиглалт тэмдэглэлийг багтаасан нь бий. Уг бүтээл нь олон талаараа өнөөгийн судлаачдын хувьд тухайн үеийн Монгол орны нийгэм, мал аж ахуйн байдлыг сурвалжлан тодруулах, цаашилбал Зөвлөлт Оросоос Монгол оронд хоршооллын үзэл санааг нэвтрүүлсэн түүхийг улируулан судлахад чухал эх сурвалж болж байна.

Энд онцлон тэмдэглэхэд И.М.Майскийн номноо бичигдсэн хоршооллын үзэл санааны “үр хөврөл” бол эцсийн дүнд монголчуудын өөрсдийн санаачлагаар буй болсон оролдлого байв. Үүнийг Зөвлөлийн дэмжлэгээр Монголд өрнүүлсэн хоршооллын үзэл санаатай огт хутган ойлгож болохгүй бөгөөд мөн чанар, агуулга, зорилгын талаар эрс тэс өөр чиглэлтэй байсан билээ. Харин И.М.Майскийн

<sup>10</sup> МУУТА, ф-М168, д-1, хн-130.

<sup>11</sup> Оросын түүхч, нэрт дипломатч, академич И. М. Майский (1884-1975) эрдэм шинжилгээний томилолтоор 1919-1920 онд Монголд ажилласан хугацаандаа цуглуулсан баримт хэрэглэгдэхүүндээ тулгуурлан эл номоо бичсэн бөгөөд энд онцлон тэмдэглэсний учир юун хэмээвээс И. М. Майский номынхоо өмнөтгөлд бичсэнээр 1919 оны хавар Бүх Оросын Эд хэрэглэгчдийн Нийгэмлэгүүдийн Төв Холбооноос Сибирийн салбарынханд Монгол мал махны зах зээлийн асуудлыг судлах даалгавар өгөгдсөн байна. Тулгар тогтоод байсан Зөвлөлт засаг хоршооллын салбарт хийх далайцтай шинэтгэлийнхээ хүрээнд тухайн үеийн Автономит Монголыг хамааруулан ач холбогдол өгч байсан нь энэ жишээнээс харагдах бөгөөд эл асуудал нь Зөвлөлтүүд Монголд “Улаан хувьсгал” хийхээс өмнөх үед хамаарч байгаа нь бүр анхаарал татаж байгаа юм. Ингэснээр И. М. Майскийн удирдсан Монгол орны эдийн засаг, төрийн байгуулал, улс төрийн амьдрал, соёл ахуйн хэвшлийг судалж материал цуглуулах тусгай экспедицийг томилсон байна. Эндээс үзэхэд Москва улс орноо хоршооллох асуудлынхаа хүрээнд Монгол орныг орхигдуулахгүй эргнээс анхаарч байсан гэлтэй. И. М. Майский энэ тухай номынхоо өмнөтгөлд “... Материал цуглуулах ажлыг би нутгийн хүмүүст /орос, монгол/ хоршооллын мөн чанар, зорилгыг тайлбарлах ажилтай хамтатган хийж байв. Орос хүнд би Эрхүүгээс авч гарсан хоршооллын тухайн омзохиол өгдөг, монголчуудад бол экспедицийн хүчээр хоршооллын зарчим, хэлбэр болон Төв Холбооны тухай өгүүлсэн бэсрэг товхимол бичиж, Өргөөд монгол хэлээр хэвлэн тарааж байлаа. Энэ товхимолыг Нийслэл Хүрээний болон аймаг хошуудын монгол албан байгууллагуудаас гадна Монгол дахь Төв Холбооны харьяа бүх байгууллагад тараасан” гэж бичжээ.

төлөвлөж судалж байсан хоршооллын үзэл санаа их удалгүй амьдралд биеллээ олж, тэр нь яван явсаар хожмын нэгдэлжих хөдөлгөөнтэй шууд уялдаж байгааг анхаарч тусгайлан судлах нь чухал байна.

Хоршооллыг хөгжүүлэх үзэл санаа нь явсаар МАХН-ын VIII Их хурлаар нийтээр хамтралжуулах кампанит ажил болон хувирсан бөгөөд “зүүнтний” удирдагчдын хэт хувьсгалжсан шийдвэр хоршоолох бодлогыг төрийн оролцоотойгоор хүчлэн шийдвэрлэснээрээ нугалаа завхрал гарах үндсийг бүрдүүлж өгчээ. Ийнхүү 1924-1927 он хүртэл БНМАУ харьцангуй бие даасан шинжтэй гадаад, дотоод бодлого явуулахыг эрмэлзэж, ЗХУ-аас гадна Европын Герман, Франц зэрэг улстай худалдаа, эдийн засаг, соёлын салбарт түншийн харилцаа тогтоохыг эрмэлзэж, дотоодод аж ахуйн хувьд иргэдийг “Бусдыг мөлжихгүйгээр нийтээр хэм тэгш хөрөнгөжих” уриалгыг дэвшүүлж байсан нь хожим МАХН-ын VII Их хурлаар капиталист бус хөгжлийн зорилгод харшилсан “барууны хэлбэрэл”-д тооцогдох болсныг бид мэдэх билээ.

Монголын нийгмийн өмчийн харьцааг зохистойгоор тэгшитгэхэд чиглэх ёстой байсан өмнөх зорилт 1927-1932 он хүртэлх 5 жилийн хугацаанд үндсээрээ өөрчлөгдөн Монгол орны мал аж ахуйн хөгжлийн гольдрилыг алдагдуулж, Коминтерний улс төрийн ашиг сонирхлын дэмжлэгтэйгээр хэт хувьсгалжиж туйлширсан, үндэснийхээ онцлогыг харгалзаагүй бодлого болон хувирав. Малын тоо толгой эдгээр жилүүдэд ихээхэн буурч байсны үндсэн шалтгаан нь хамтралжуулалтаас гарсан сөрөг үр дагаваруудтай голлон хамааралтай нь тодорхой боловч дам шинжтэй зарим нөлөөлөл байсныг бас мартаха аргагүй юм. Жишээлбэл, Монгол Ардын Төв Кооперативаас гадаадад (ЗХУ-д Р.Т) гаргах мал худалдан авах явц 1929 оноос ихээхэн өргөжиж ирсэн байна. Хэдийгээр 1929 оноос өмнө малчид малаа олноор худалдах сонирхол байсан боловч малыг гадаадын зах зээлд худалдан борлуулах нь өргөн хэмжээтэй зохион байгуулагдаж байсангүй.

МАХН-ын IX Их хуралд хоршооны ажлын талаар бэлтгэсэн илтгэлийн эхэд тэмдэглэсэнээр бүдүүвчилсэн байдлаар тооцвол өмнө нь жил тутам Монголоос нийлүүлэн гаргаж байсан бод мал 40-50 мянга, бог мал 400-500 мянган толгой хүрч байв.<sup>12</sup> Энэ талаар уг илтгэлд дурдахдаа “...сүүлийн үест нэвтрүүлэн гаргасан малын тоо 20-25 мянга хүртэл доошилж ирсэн атал 1929 онд СССР-ийн худалдааны байгууллагуудаас урьд жилүүдэд худалдан авч байснаас үлэмж олон тоо бүхий мал худалдан авах хэмээхийг тус орны худалдааны байгууллагуудаас хүлээн ашигласан тул энэхүү 1929 оноос эхлэн гадаадад нэвтрүүлэхээр мал худалдан авах

<sup>12</sup> МАХН-ын Баримтын Төв, Фонд-2, Данс-8, Хадгаламжийн нэгж-39, 63-рхуудас.

явдал дахин нэмэгдэж ирсэн.”<sup>13</sup> гэсэн байдаг. Энэ бол үнэхээр анхаарахгүй өнгөрч болохгүй асуудал юм. Иймд 1929-1933 онд Төв Кооперативын байгууллагаар дамжуулан худалдан авч гадаадад гаргасан малын тоон үзүүлэлтийг авч үзье.

Худалдах мал	Он				
	1929	1930	1931	1932	1933
Худалдан авахаар төлөвлөсөн үхрийн тоо		3 800	84 000	120 000	56 000
Жинхэнэ худалдан авсан үхрийн тоо	15 275	40 631	57 035	42 000	14 256
Худалдан авахаар төлөвлөсөн бог малын тоо		25 000	618 000	667 000	552 500
Жинхэнэ худалдан авсан бог малын тоо		219 258	417 604	360 000	885 843
Худалдан авахаар төлөвлөсөн махны адууны тоо			20 000	5 000	2 000
Жинхэнэ худалдан авсан махны адууны тоо			10 500	5 000	4 388

Эх сурвалж: МАХН-ын Баримтын Төв, Фонд-2, Данс-8, Хадгаламжийн нэгж-39, 63-рхуудас

Эндээс тооцож үзэхэд 1929-1933 оны хооронд манай улс Төв Кооперативаар дамжуулан үхэр 169 197, адуу 19 888, хонь, ямаа 1 882 705 тоо толгойг ЗХУ-д худалдсан үзүүлэлт гарч байгаа бөгөөд 1930-1932 онд (IX Их Хурлын “Улс төрийн ерөнхий илтгэл”-д дурдсанаар) манай улсын нийт малын тоо 23,6-16,1 сая орчимд байсан гэж үзвэл ЗХУ-д гаргаж худалдсан малын тоо жил тутам ихээхэн нэмэгдэж байсныг ажиглаж болно. “Монгол ард улсыг аж ахуй ба эрдэм соёлын хувиар хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөө”-гөөр 1930-1935 он хүртэл мал сүргийн тоо толгойг төрөл тус бүрээр өсгөхөөр шийдвэрлэсэн бөгөөд МАХН-ын Баримтын төвд өдгөө хадгалагдан буй орос хэлнээ бичигдсэн тус төлөвлөгөөг боловсруулахад ЗХУ-ын мэргэжилтнүүд голлон ажилласан нь гарцаагүй юм. Өөрөөр хэлбэл, ЗХУ-д мал худалдаалах, Монголын малын тоо толгойг өсгөх төлөвлөгөө зэрэг нь эцэстээ ЗХУ-ын эдийн засгийн алсын сонирхолтой холбогдож байсан бололтой. Малын өсөлт өндөр байсан хэдий ч тоо толгой өсөхгүй байсны гол шалтгаан, хүчин зүйлийн нэг нь өмнө дурдсанчлан гадаадад гаргах малын тоо эрс өссөнтэй холбоотой байжээ.

МАХН-ын VII их хурал 1928 оны 10 дугаар сарын 23-нд эхэлж, 50 хоног үргэлжлэн 12 дугаар сарын 11-нд дуусав. Тус хурлаас зүүнтнүүд Коминтерний

<sup>13</sup> МАХН-ын Баримтын Төв, Фонд-2, Данс-8, Хадгаламжийн нэгж-39, 63-рхуудас.



шууд дэмжлэгтэйгээр засгийн бүх эрхийг авч Монголын нийгмийн хөрөнгөлөг хэсгийг үнэн хэрэгтээ устгах чиглэлтэй бодлого баримтлан мал хөрөнгийг улсад анх удаа хураах үйл явц төрийн албадлага, хүчирхийллийн шинж чанарыг агуулан хэрэгжив. Ийнхүү МАХН-ын VII, VIII их хурлаар сайшаан баталсан “Монгол ард улсыг аж ахуй ба эрдэм соёлын хувиар хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөө”-ний илтгэлийг сонсоод Бүгд хурлаас нэмж оруулбал зохих зүйлүүдийн жагсаалтын 6 дугаарт дурдахдаа “тус улсын бүх ядуу өрхийн 70/100 ба дунд өрхийн 50/100 хувийг мал ба газар тариалангийн хамтарсан аж ахуйнуудад элсүүлэн оруулах явдлыг тус таван жилийн төлөвлөгөөнд нарийн тодорхойгоор төлөвлөн оруулбал зохино”<sup>14</sup> гэж зааснаар Монгол оронд хамтралжуулах бодлого эхэлжээ.

### **Хувьсгалт хамтралжуулалт: Дотоод зөрчил ба бодит байдал**

МАХН өмчлөлийн хувьд нийгмийг тэгшитгэж, ядуу малчдын амьжиргааг дээшлүүлэхэд улсаас туслах эдийн засгийн чадамж нөөцийг бий болгон цаашид хамтралуудыг байгуулах замаар дээрх хураасан хөрөнгөө ядууст тараан хуваарилах бодлого барьж байв. Энэ зохицуулалтаар 1930-1932 онд БНМАУ-д 840 гаруй хамтрал байгуулагдаж, 55.7 мянган өрх түүнд хамрагджээ.<sup>15</sup>

Энэ нь нийт малчдын 33 хувийг хамарч байсан гэх боловч үнэн хэрэгтээ хувьдаа 100-аас дээш бодтой бүх малчдыг “нударганы анги”-д хамааруулж, улс төр, эдийн засгийн албадлага явуулсны үр дүнд бий болгосон зохиомол үзүүлэлт байлаа. Намын IX Их хурлын тайлан илтгэлд зарим аймагт ардуудын 40-80 хүртэл хувийг хамтралжуулсан бөгөөд ядуу ардуудын 34 хувь нь хамтралд хамрагдсан тооцоог Мал, тариалангийн яамнаас гаргаж байснаас үзвэл дээрх үзүүлэлт мадаггүй бололтой.<sup>16</sup>

Гэвч харамсалтай нь хамтралжуулах бодлогын дагуу 1930-1932 онд Монгол оронд байгуулагдсан 840 гаруй хамтралаас нийслэл орчимд байсан зарим хамтралыг эс тооцвол бараг бүгд ашиггүй ажиллаж дампуурсан байна.<sup>17</sup>

Хамтын өмчит нийгмийг буй болгох талаар хүчлэн хийгдсэн энэхүү бодлого амжилт олоогүйн шалтгаан нь Монголд ч, Зөвлөлтөд ч хамтралыг эдийн засгийн агуулгаар удирдах тогтсон гэмээр үзэл концепцийн талаар тун хангалтгүй байсантай холбоотой юм. Энэ талаар Ю.Г.Иванов, Б.И.Кочуров нар ЗХУ дахь

<sup>14</sup> УТНОНББА, ф-2, д-8, хн-39 (Основные проблемы пятилетнего плана хозяйственного и культурного строительства МНР), х.46.

<sup>15</sup> *Үнэн сонин*, 1931.01.03.

<sup>16</sup> *Монгол Ардын Хувьсгалт Намын IX Их хурал (Дэлгэрэнгүй тайлан)*, Улаанбаатар, 1984, 65.

<sup>17</sup> *Үнэн сонин*, Улаанбаатар, 1931.01.03.



хамтралуудын газрын асуудалд анхаарал хандуулсан өгүүлэлдээ “...1930-аад оноос эхэлсэн хамтралжуулах хөдөлгөөн нь өнөөг хүртэл газар зохион байгуулалтын өөрийн онолыг бий болгож чадаагүй. Бүсийн төлөвлөлт хийж байх үед “тосгодын хэтийн зохион байгуулалт”-ыг үндсэн тоон мэдээ авах замаар газар зохион байгуулагчид нь улсын статистикийн мэдээнд газрын сангийн бодит тоон утгыг өөрчлөн хамтралын амжилтыг өгүүлэх олон тооны эрдэм шинжилгээний бүтээл нийтэлж байсан”<sup>18</sup> тухай өгүүлснээс үзвэл ЗХУ-д ч анхнаасаа хоршоолох бодлогын хүрээн дэх эдийн засгийн суурь асуудал болох газрын харилцааны өргөн хүрээтэй асуудал тогтсон концепцигүй хэрэгжсэн бололтой байна.

Ялангуяа Монгол оронд өрнөж байсан энэ үйл явцыг хэт түргэдсэн, тооцоо судалгаагүй, хэсэг бүлэг “боловсролгүй этгээдүүд”-ийн санааны зоргоор явагдаж байгаа үйл явц хэмээн үзэж, гадаад талаас төдийлөн хүчтэй дэмжлэг үзүүлээгүй байна. Өмнөх түүх бичлэгт хамтралжуулах үйл явцын дампуурлыг улс төрийн хүчин зүйлийн нөлөөллийн хувьд түлхүү авч үзсээр ирсэн боловч энэ нь мөн чанараараа цэвэр эдийн засгийн агуулгатай шууд холбогдож байсан нь нэгэнт тодорхой болж байна. ЗХУ-ын архивын баримтуудад энэ талаар нэлээдгүй өгүүлсэн нь бий.

Тухайлбал, 1930 оны тайлан мэдээнд дурдсанаар “... бараг бүх хамтралд хүнсний хуваарилалтын тал дээр хэрүүл маргаан байна. Хамтралуудад байгаа илүү эд юмтай, эрүүл хүмүүст хүнс өгөхгүй, харин хоосон, ажил хөдөлмөр хийх чадалгүй, өвчтэй хүмүүст нормын хүнс өгнө гэснээс болж ийм байдал үүсээд байна. Ингэхээр эрүүл хүмүүс нь заавал ажиллах ёстой, гэхдээ тэдэнд хүнс өгөхгүй байгаа явдалд энэ тэр ажлыг хийж байгаа эхний ангиллын хүмүүс ихээхэн дургүйцэж байна. Үүнээс улбаалан олон хүн хамтралаас гарах тухайгаа хэлэх боллоо”<sup>19</sup> гэж бичсэн нь эрхгүй анхаарал татаж байгаа юм.

Зөвлөлтөд ч, Монгол ч хамтралжуулах бодлогод дүн шинжилгээ хийх бодит шаардлага гарч ирэв. И.В.Сталин хамтралжуулах үйл явцын ололт ба алдааг зэрэгцүүлэн авч үзсэн “Амжилтаасаа толгой эргэх нь” хэмээх нийтлэлээ 1930 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн “Правда” сонинд гаргав. Уг нийтлэлд хамтралын байгуулалтын нийтлэг алдаа дутагдлыг зураглахыг хичээж, “... Хөгжингүй бүс нутгийн хамтралын байгуулалтын жишээг хөгжөөгүй бүс нутагт механикаар буулгаж болохгүй. Энэ ч гэсэн тэнэг бөгөөд харгис явдал. Ийм “бодлого” бол

<sup>18</sup> Иванов, Ю.Г., Кочуров, Б.И. “Содержании теории землепользования”, *Проблемы региональной экологии* 3(2004): 84-88.

<sup>19</sup> *Монголия в документах из архивов ФСБ России (1922-1936 гг)*, Российская Академия Наук Институт Востоковедения, Федеральная Служба Безопасности России Центральный Архив, Москва, 2019, стр.315

хамтралжуулах хөдөлгөөнийг нэг цохилтоор нэр хүндгүй болгоно”<sup>20</sup> гэж дурдсан нь ЗХУ-ын хамтралын бодлогыг сохроор шахам хуулбарлаж байсан манай нам, төрийн “зүүнтэн” удирдагчдад ч ихээхэн хамаатай үг байсан юм.

Тухайн үед Монгол оронд хамтрал байгуулж, ард түмний хувийн өмчийг улсад хураан авах үйл явцыг төдий л дэмжихгүй байсан Зөвлөлт засгийн байр суурийг илтгэх архивын баримтууд цөөнгүй хадгалагдан үлджээ. Тухайлбал, Монголын нам, засаг ардын аж ахуйг нэгтгэхээр эхэлсэн боловч энэ үйл ажиллагааг түр зогсоогоод байна. Москвагаас хамтрал байгуулах ажлыг түр азнах удирдамж өгснийг Монголын Засгийн газар авсан гэдэг таамаглал байна. Учир нь Монголд хамтрал байгуулах цаг үе нь арай болоогүй болов уу” гэж ЗХУ-ын тал үзэж байлаа.<sup>21</sup>

Монголын нийгмийн дээд давхаргыг өмч хөрөнгө, улс төрийн эрх, газар бэлчээрийн талаар хумин боогдуулсан дээрх бодлогыг тухайн үеийн “зүүнтэн” удирдагчдаас ч өөрсдөө бодитой эсэргүүцэж байв. Хамтралжуулалтын алдааг зүүнтнүүд дотроосоо зоригтойгоор илчлэн шүүмжлэх уур амьсгал бүрэлдэхэд И.В.Сталины дээрх нийтлэл чухал түлхэц үзүүлсэн нь тодорхой байна.

1930 оны 7 дугаар сард МАХН-ын зорилго, бодлого, тус улсын цаашдын хөгжилтийн тухай асуудлаар Ө.Бадрахаас В.М.Молотов, М.М.Каганович нарт, мөн оны 10 дугаар сард И.В.Сталинд бичсэн түүний хувийн захидлууд нь хамтралжуулалт, феодалын хөрөнгө хураалтын үйл явцын тухай МАХН-ын “зүүний” удирдлагын дотоод зөрчлийн чиг хандлагыг тодорхой тусган агуулжээ. Уг албан захидалд “... Цэцэрлэг, Тайшир, Богд хан зэрэг аймгуудад комиссоор гаргасан П.Гэндэн, Б.Элдэв-Очир, Р.Мэнд нарын зэрэг хариуцлагатай удирдагч нараас жинхэнэ коммуны шатны артелиуд буюу ялангуяа коммунуудыг өдий олноор байгуулж, айл ардуудыг өртөө улаагаар буюу феодал баячуудын хөрөнгө хөсгөөр хөөн нүүлгэж нийлүүлж суурьшуулах зэргийн чухам албадлага хавчлага хэмээхийн анхны зохиолыг удирдан байгуулаад ирсэн бөлгөө”<sup>22</sup> гэж бичсэнээс үзвэл зүүнтний удирдагчид хамтралжуулах үзэл баримтлалын хувьд дотооддоо ихээхэн зөрчилтэй байсан нь тодорхой харагдана.

1930 онд хуралдсан МАХН-ын VIII Их хурлаас гарсан хамтрал коммуны алдаа нугалааны талаарх илтгэлд мөн энэ талаар тодорхой дурдсаныг авч үзвэл

<sup>20</sup> Сталин, И.В. “Головокружение от успехов: К вопросам колхозного движения”, *Правда*, №60, Москва, 2 марта 1930г.

<sup>21</sup> *Монголия в документах из архивов ФСБ России (1922-1936 гг)*, Российская Академия Наук Институт Востоковедения, Федеральная Служба Безопасности России Центральный Архив, Москва, 2019, стр.239

<sup>22</sup> УТНОНББА, ф-1, д-1, хн-74, х.2.

“... Намын VIII Их хурлаас манай орны хувьсгалыг нийгэм журмын хувьсгал хэмээн буруугаар шинжилснээ баримталж, хамтралын байгуулалтыг хийх ба нударганчуудыг устгах хийгээд энгийн худалдаачдыг хавчих болон хөрөнгөлөг этгээдэд өсгөн үржүүлэх журмын албан татварыг ноогдуулах зэргийн өдий төдий буруу тогтоолуудыг гаргасны дээр зөвхөн феодалуудыг бус харин чинээлэг ардуудыг хавчихаар тогтоосон нь тус улсын эдийн засгийн байдал ба олон нийтийн харилцаанд өчүүхэн төдий тохирохгүй байсан”<sup>23</sup> гэж дүгнэжээ.

Үнэхээр ч хамтралууд олноор байгуулагдаж байсан 1930-аад оны Монгол орон дахь завхрал гажуудлын талаар өмнө олон эрдэмтэн бүтээлдээ бичиж байсныг бид мэднэ. Төвлөрсөн бодлого зохион байгуулалтаар сул явагдсан энэ үйл явцын бодит дүр төрхийг тодотгох үүднээс тухайн үеийн Зөвлөлтийн эх сурвалжаас эш татан авч үзье. 1930 оны 5-6 дугаар сарын байдлаар Монголын зүүн бүсэд олноор байгуулагдсан хамтралуудын бодит байдал дараах байдалтайгаар өрнөж байсныг дор дурдвал, “... Өлзий болон Гурванбаян хамтралд мал маш их хорогдож байгаа тухай, ялангуяа хонь өдөрт 20-30 толгойгоороо хорогдон малчид заримых нь арьсыг ч өвчиж амжихгүй байгаа тухай Өлзий хошуунаас ирсэн Монценкоопын ядуу малчин Чүлтэм, Балсан мэдээлэл өгөв. Малчид малаа муу маллаж, ямар ч хариулгагүй талд эзгүй орхисноос болж мал ингэж ихээрээ үрэгдэж байна. Хамтралуудад удирдлага заавар өгч байгаа хүн бараг л алга. Улаанбаатараас хамтралын хөдөлгөөний зааварлагчаар ирсэн Бат хамтралуудаар бараг л явдаггүй, Балган тайжийнд Баянтүмэнд л сууж байдаг гэж тэр ярьж байна. Мөн хуучин лам байгаад өнгөрсөн жил хар болсон хамтралын нярав Балдансамбуу байнга архи ууж, согтуу байдаг тухай Баянтүмэнгийн хамтралын гишүүн Цэнд, Цэцэг нар ярьж байна. Тэд өөрсдөө нэг биш удаа, бүр нэлээн хэдэн удаа түүнд архи хүргэж өгч байсан бөгөөд ингэж согтуу хөлчүү байснаас болж хамтралын мөнгөн дүнгээс 1000 орчим төгрөг дутаад байгаа гэнэ. Түүнтэй хамт хамтралын захиргааны бичээч Билэг бас уудаг. Одоо мөнгөн дүнгээр тайлан тооцоогоо өгөх болсон, тиймээс тэд ямар нэг аргаар дутааснаа нуун дарагдуулах гэж үгсэн хуйвалдаж байна” гэж тэмдэглэжээ.<sup>24</sup>

Ийнхүү “зүүнтний” жилүүдэд монголчуудын аж ахуй, соёлын уламжлалт амьдралыг охор хугацаанд үндсээр өөрчлөхийг оролдсон хийрхэлт үйл ажиллагаа олноор явуулснаас 1932 онд тус улсын Архангай, Хөвсгөл, Завхан /мөн бусад

<sup>23</sup> Мөн тэнд, 43.

<sup>24</sup> *Монголия в документах из архивов ФСБ России (1922-1936 гг)*, Российская Академия Наук Институт Востоковедения, Федеральная Служба Безопасности России Центральный Архив, Москва, 2019, стр.315.

аймгуудад малчид нутгаасаа дүрвэн нүүх үзэгдэл газар авч байжээ/ аймгийг хамарсан зэвсэгт бослого гарсан ч төрөөс хүч хэрэглэн цус урсгаж дарсан юм.<sup>25</sup>

1932 оны 5 дугаар сарын 16-ны БХК(б) намын хуралдаанаас гаргасан 171 дүгээр тогтоолд 1932 оны бослогын нөхцөл, шалтгааныг дүгнэхдээ “Монгол нөхдийн үндсэн алдаа бол Зөвлөлт Бүгд Найрамдах Улс бол хөгжсөн аж үйлдвэртэй, пролетари бүхий социалист улс, харин Бүгд Найрамдах Монгол Улс бол хөрөнгөтний ардын ардчилсан улс гэдгийг ойлгохгүй, ЗСБНХУ-ын Зөвлөлт засгийн бодлогыг тэд сохроор хуулж байгаад оршиж байна. Энэ алдаа бол одоо Монголд өрнөж байгаа бослогын гол шалтгаан мөн”<sup>26</sup> гэж дүгнэжээ.

Өөрөөр хэлбэл, 1950-аад он хүртэл Монгол оронд социализм байгуулах талаар дурдсан албаны ямар нэгэн баримт байдаггүй учраас ЗХУ-ын бодит нөлөөллийг эргэн харж судлах, уг асуудлаарх гадаад, дотоод орчны төлөв байдлыг харьцуулан шинэ өнцөгөөр авч судлах нь чухал болж байна.

Зүүнтний хамтралжуулах бодлого ийнхүү нийгмийн завхрал болж хувирсан 1930-аад оны энэ жилүүдэд малчдын дунд хамтын аж ахуйн тухайд тун таагүй сэтгэгдэл үлдсэн билээ. БНМАУ-д хөдөө аж ахуй талаар завхрал явагдаж байгаа тухай БХК(б) намын удирдах хэсэг ч дээрх мэтээр хүлээн зөвшөөрч шүүмжилж байсан энэхүү сэдэв хожим МАХН-ын нэгдэлжих хөдөлгөөний хэрэгжилтэд ч ихээхэн сөргөөр нөлөөлсөн юм. Түүхийн богино хугацаанд 700 гаруй сүм хийдийг эвдэн нурааж, сэхээтэн, лам нарыг үй олноор хэлмэгдүүлснээр угсаатны хувьд геноцит ажиллагаа явуулж, Монголын нийгмийн уламжлалт соёл, оюун санааны суурийг үнэн хэрэгтээ устгажээ. Үүнтэй зэрэгцэн Анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазарын үеэс олон зууныг дамжин тогтвортой оршсоор ирсэн сүм хийдийн газар ашиглалтын уламжлал энэ үеэс үгүй болсон байна.<sup>27</sup>

Өөрөөр хэлбэл, Монгол орны газар ашиглалтын түүхэнд онцгой байр суурь эзлэх Богдын Их шавь, тамгатай болон тамгагүй хутагт хувилгаадын эзэмшил газар нутаг, түүний бэлчээр нутаг үндсэндээ үгүй болж, дахин сэргээгүй байна. 1934 оны 9 дүгээр тал сарын 28-наас 10 дугаар сарын 5-ныг өдрийг хүртэл хуралдсан МАХН-ын IX Их хурал хамтрал коммуны үеийн нугалаа завхралыг засахад чиглэгдсэн “Шинэ эргэлт”-ийн бодлогыг тунхагласан бөгөөд тус хуралд Төв Хорооны тэргүүлэгч гишүүн П.Гэндэн “Төв Хорооны улс төрийн тайлан илтгэл”-ийг тавьсан юм.

<sup>25</sup> Насанбалжир, Ц. *Монголын мал аж ахуй хөтлөлтийн уламжлал, шинэтгэл (XIX зууны эцэс XX зууны эхэн)*, Хянасан Х. Пэрлээ, Улаанбаатар, 1978, 67.

<sup>26</sup> *Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичигт (1921-1932), Баримтын эмхтгэл*, боть I, Улаанбаатар, 2002, 371.

<sup>27</sup> Болдбаатар, Ж. *Түүх зулсан он жилүүдийн ойллого*, II боть, Улаанбаатар, 2003.

Тэрээр “зүүнтний” жилүүдийн дараах БНМАУ-ын мал аж ахуйн байдлыг дүгнэхдээ “...Улсын сангийн аж ахуй ба коммуунуудыг байгуулахыг зорьж бид нараас ардын хувийн аж ахуйг хөгжүүлэх тухай анхаарлаа тавихыг зогссоноор үл барам чинээлэг ба дундаж хүртэл ардын тухай манай явуулж байсан албан татварын бодлого болбоос энэхүү аж ахуйг сүйтгэж, малын тоог эрс хорогдуулахад хүргүүлсэн болой”<sup>28</sup> гээд хамтралын үеийн хоёрхон жилийн жишээгээр авч үзвэл 7 сая 200 мянган толгой мал үрэгдсэн тухай дурдаж, ингэснээр мал сүргийн тоонд ямар өөрчлөлт гарсан талаар тодорхойлсон байна.

Хэдийгээр тухайн үеийн статистикууд ихээхэн зөрөөтэй байдаг боловч 1930-1932 оны хооронд Монгол орны мал сүргийн тоо дээрх хуудуутай бодлогын уршгаар 33 орчим хувиар хорогдсон дүн гарч байгаа юм. Энэ утгаар авч үзвэл мал аж ахуйн өмчлөлийн харьцаанд өөрчлөлт гарахтай зэрэгцэн ядуу, дунд ардуудын хувьд хамтралжуулах бодлогоор эхлэлээ тавьсан хоршооллын үүслийн түүх нь нааштай байтугай харин ч нэн сөрөг үр дагавар авчирсан нь тодорхой байна.

Энэ үеийн нийгмийн өөрчлөлт хамгийн эмзэгээр туссан хэсэг бол дундаж болон ядуу ардууд байв. 1920-иод оны сүүл үе болоход эдгээр давхаргынхан 20 хүртэл бодтой нийт малчдын 65,5 хувийг эзэлж байжээ. Түүнчлэн, А.Д.Симуков 1932 оны байдлаар 25 хот айлын дунд судалгаа явуулж үзэхэд судалгаанд хамрагдсан нийт өрхийн 34 хувь нь амьжиргааны хувьд аль нэгэн чинээлэг малчныг түшиглэсэн, аж ахуйн хувьд хараат бусдын гар харсан амьдралтай байжээ.<sup>29</sup>

Иймд улсаас ядуусыг нийгмийн дундаж хэмжээнд татан аваачих бодлого явуулснаар энэ үзүүлэлт 1939 оны байдлаар ихээхэн өөрчлөгдөж, Монголын нийгмийн давхраажилтад дундаж амьжиргаатай иргэдийн (20-100 бодтой) эзлэх хувь хэмжээ давамгайлах болж, нийт хүн амын 43 хувь, мал сүргийн 67,2 хувийг зөвхөн энэ хэсэг өмчлөх болсон байдаг.<sup>30</sup>

Дээрх бүх статистик судалгаанаас харахад нийгмийн дийлэнх хэсгийг бүрдүүлж байсан ядуу, дундаж хэсгийн хувьд голчлон амьжиргаагаа залгуулах хэмжээнд байсаар иржээ. Өөрөөр хэлбэл, тухайн үед тэдний өмчлөлд байсан аж ахуйн үндэс болох мал сүрэг нь эдийн засгийн агуулгаараа чухал үүрэгтэй боловч хэмжээний хувьд эл хэсгийн нийгмийн баталгаа болж чадаагүй бөгөөд чинээлэг болон ядуу хэсгийн дунд “хөвөгч” байдалтай оршиход нөлөөлж байв.

<sup>28</sup> *Монгол Ардын Хувьсгалт Намын IX Их хурал (Дэлгэрэнгүй тайлан)*, Улаанбаатар, 1984, 64.

<sup>29</sup> *Нямын Жагварал (Амьдрал үйл, үзэл баримтлал)*, хянан тохиолдуулсан Х.Цэвлээ, хэвлүүлсэн менежер Ц.Отхон, Улаанбаатар, 2000, 416.

<sup>30</sup> Лувсандорж, С нар. *Хөдөө аж ахуйн хоршооллын үүсэл, хөгжил, шинэчлэл*, Улаанбаатар, 2006, 57.

Иймд дурдан буй үеийн Монгол орны хангай, говь, тал хээр, уулын бүсийн аймгуудыг бүсчилсэн байдлаар тогтолцоотойгоор харьцуулан судлах нь бидний судалгаанд чухал ач холбогдолтой байх болно. Орон нутгууд дахь мал сүргийн бүтэц, онцлог байдал, тоо хэмжээ, тархац, нягтрал, нэг аж ахуй, хүнд оногдох малын сүргийн өмчлөлийн харьцаа, газар бэлчээр эзэмших байдал зэрэг нь харилцан адилгүйгээр барахгүй тухайн аймгуудын доторх бүсүүдэд ч чамгүй ялгаатай байжээ. Үүний дээр судалгаа статистик нь нэлээд задлага байдлаар хийгдсэн учраас бүсүүдийн мэдээг нэгтгэж бодоход хүндрэлтэй байна.<sup>31</sup>

Харин А.Д.Симуков зэрэг Зөвлөлтийн эрдэмтдийн анхлан хийсэн уг судалгаа нь Монгол орны хөдөө аж ахуйг хожим нийтээр хоршоолох, газар зүйн онцлог байдалд тохируулан бодлогоо хэрэгжүүлэхэд чухал хэрэглэгдэхүүн бүхий анхны шинжлэх ухаанч ажил байсан бөгөөд ЗХУ-ын дэмжлэгтэй хэрэгжсэн хожмын нэгдэлжих хөдөлгөөний шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулахад чухал түлхэц үзүүлжээ.

### Дүгнэлт

БНМАУ дахь хамтралжуулах үйл явцын эхлэл нь “зөвлөлтжүүлэх бодлого”-ын мөн чанар, агуулгаар дэвшигдэн гарч ирэхийн зэрэгцээгээр дэлхийн социалист системийн бүрэлдэхүүн, их гүрнээс нүүдлийн соёлоор он удаан жил амьдарч ирсэн монголчуудын амьдралын тогтсон хэвшил, соёлыг түүхийн богино хугацаанд өөрчлөн хувьсахаар зорьсон бодлого, улс төрийн эрх ашгийн нөлөө тусгал, түүнийг дагасан эдийн засаг, соёл, боловсролын дэмжлэг тусламжийг сүлэлдүүлэн явагдах үндсийг энэ үед тавьжээ.

Үүний тод илрэл нь хамтралжуулалтаар анхлан хэрэгжсэн бөгөөд 1929-1932 оны зүүнтний жилүүдэд мал аж ахуйн өмчлөлийн талаар голлон анхаарч Монголын нийгмийн дээд давхаргын эсрэг чиглэсэн улс төр, эдийн засгийн хүчирхийлэл, төрийн албадлагын бодлогыг хэрэгжүүлсэн боловч улс орны эдийн засгийн хөгжлийн үндэс болсон газар бэлчээрийн харилцааны асуудал зэрэг суурь үзүүлэлтүүдийг огт анхаарахгүй өнгөрсөн байна.

<sup>31</sup> Simukov, A. 1993 [1936]. *Materiali po kochevomy bitu naseleniya MNR* (Materials on the Nomadic Way of Life of the Population of Mongolia). *Salskie Khovelsvo Mongolii* [Ulaanbaatar]: 49-56. Originally published in *Sovremini Mongolii* 2 (15): 49-57; А.Д.Симуков, *Труды о Монголии (1934) и для Монголии*, Том I, составители Юки Конагая, С.Баяраа, И.Лхагвасүрэн, *Senri Ethnological Reports*-66, Государственный музей этнологии Осака 2007, 976 p; Maria E. Fernandez-Gimenez, “Sustaining the Steppes: A Geographical History of Pastoral Land Use in Mongolia”, *Geographical Review* 89(1999): 315-342.

Дээрх эх сурвалж баримтуудаас үзэхэд хамтралжуулалтаар дамжин Монгол оронд хоршоолох үйл явц эхлэлээ тавьсан хэдий боловч “зөвлөлтжүүлэх бодлого” өрнөж, их гүрний улс төрийн шахалтаар уг үйл явц хэрэгжсэн хэмээн үздэг уламжлалт дүгнэлтийг эргэн харах шаардлагатай болж байна. Өөрөөр хэлбэл, Зөвлөлт Орос улсаас Монгол оронд хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа нь тус улсад нөлөөний хүрээгээ баттай хадгалах чиглэлд түлхүү хэрэгжсэн гэж үзэхэд хүргэж байна.

Харин эдийн засгийн агуулгын хувьд бодлогын бодитой дэмжлэг үзүүлэхүйц хэмжээнд хүрч хэрэгжээгүй нь тодорхой байна. Иймд мал нийгэмчлэхүйл явцын эхлэл цэг болсон хамтралжуулалтын түүхийг хожмын нэгдэлжих хөдөлгөөнтэй ухаарал сургамжийн хувьд холбон судлах шаардлага үүсвэл тэрхүү нөлөөллийг эдийн засгийн агуулгаар харах, түүний тулд дотоодын санаачлагаар хэрэгжүүлсэн бодит бодлоготойгоо холбон авч судлах, алдаа, оноогоо гадаад хүчин зүйлээс бус дотоодоосоо илүүтэй эрж хайх нь чухал болж байгааг тэмдэглэе.

## **Abstract**

### **Review of the Soviet influence in the collectivization**

The article focuses to review the real influence of Soviet Russia on the history of Mongolian agricultural cooperatives in the early 1930s, which was the starting point of the collectivization movement (negdel) and left a legacy of understanding and lessons about cooperatives. This emphasizes the researcher's position as to whether co-operation was in fact an embryo of «Soviet policy» in the history of the Mongolian economy. In other words, we will revisit the previous concept, which was interpreted mainly in connection with the position of Soviet Russia and the influence of political policy. The article also try to clarify on Mongolia's extreme revolution, distortions, and the inactive stance of the Soviet Union on economic development in the Mongolian People's Republic, especially on issues of integration, and draws reality at the crossroads of these issues.

## **Ном зүй**

### ***Архивын эх сурвалж***

1. МАХН-ын Баримтын Төв, Фонд-2, Данс-8, Хадгаламжийн нэгж-39.
2. МАХН-ын Баримтын Төв, Фонд-2, Данс-8, Хадгаламжийн нэгж-39.
3. МУУТА, ф-М168, д-1, хн-130.
4. УТНОНББА, ф-1, д-1, хн-74.
5. УТНОНББА, ф-2, д-8, хн-39 (Основные проблемы пятилетнего плана хозяйственного и культурного строительства МНР)



### **Баримт бичгийн эмхэтгэл, тогтмол хэвлэл**

1. *Монгол Ардын Нам сэтгүүл*. Нийслэл Хүрээ 1(1923), 17-19-р тал.
2. *Үнэн сонин*, Улаанбаатар 1931.01.03.
3. *Монгол Ардын Хувьсгалт Намын IX Их хурал* (Дэлгэрэнгүй тайлан). Улаанбаатар, 1984.
4. *Үнэн сонин*. Улаанбаатар, 1931.01.03.
5. *Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1920-1940*, Нэгдүгээр дэвтэр, Улаанбаатар, 1966.
6. *Монгол Ардын Хувьсгалт Намын IX Их хурал* (Дэлгэрэнгүй тайлан). Улаанбаатар, 1984, 64.
7. *Монголия в документах из архивов ФСБ России (1922-1936 гг)*. Российская Академия Наук Институт Востоковедения, Федеральная Служба Безопасности России Центральный Архив, Москва, 2019.
8. *Монголын тухай БХК(б)Н-ын баримт бичиг (1921-1932)*, Баримтын эмхтгэл, боть I, Улаанбаатар, 2002, 371.

### **Нэгэн сэдэвт бүтээл**

1. Ленин, В.И. *Түүвэр зохиол*. 23, 31 дүгээр боть.
2. Майский, М.И. *Орчин үеийн Монгол*. Орос хэлнээс орчуулсан Ц. Отхон, Улаанбаатар, 2001, 252-р тал.
3. Маркс, К., Энгельс, Ф. *Түүвэр зохиол*. 2 дугаар боть, Улаанбаатар, 1970.
4. Маркс, К., Энгельс, Ф. Соч Т-27.
5. Цэдэнбал, Ю. *Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг*, II боть, Улаанбаатар, 1967.
6. Ядамсүрэн, Ж. *Капиталист биш хөгжлийн замын тухай онол, Монголд судлагдсан байдал*, Редактор Б.Даш-Ёндон, Улаанбаатар: Сэлэнгэпресс, 2012.
7. Siegfried Schieder, Manuela Spindler (Hrsg.) *Theorien der Internationalen Beziehungen*, 3. Auflage, "Lenins Imperialismustheorie", Verlag Barbara Budrich, 2010.
8. Болдбаатар, Ж. *Түүх зулсан он жилүүдийн ойллого*, II боть, Улаанбаатар, 2003.
9. Лувсандорж, С нар. *Хөдөө аж ахуйн хориооллын үүсэл, хөгжил, шинэчлэл*, Улаанбаатар, 2006, 57.
10. Насанбалжир, Ц. *Монголын мал аж ахуй хөтлөлтийн уламжлал, шинэтгэл (XIX зууны эцэс XX зууны эхэн)*, Хянасан Х. Пэрлээ, Улаанбаатар, 1978.
11. *Нямын Жагварал (Амьдрал үйл, үзэл баримтлал)*, хянан тохиолдуулсан Х.Цэвлээ, хэвлүүлсэн менежер Ц.Отхон, Улаанбаатар, 2000, 416.
12. Симуков, А.Д. *Труды о Монголии (1934) и для Монголии*, Том I, составители Юки Конаяга, С.Баяраа, И.Лхагвасүрэн, *Senri Ethnological Reports-66*, Государственный музей этнологии Осака 2007, 976 p.

*Эрдэм шинжилгээний өгүүлэл*

1. Maria E. Fernandez-Gimenez, “Sustaining the Steppes: A Geographical History of Pastoral Land Use in Mongolia”, *Geographical Review* 89 (1999): 315-342.
2. Чулуунбаатар, Л. “Түүхэн үйл явцын их масштабын шатлал ба Иргэншлийн онол”, *Түүхийн судалгааны онол-арга зүйн асуудал*, Улаанбаатар, 1999, 99.
3. Иванов, Ю.Г., Кочуров, Б.И. “Содержании теории землепользования”, *Проблемы региональной экологии* 3(2004): 84-88.
4. Simukov, A. 1993 [1936]. *Materiali po kochevomybitunaseleniya MNR* (Materials on the Nomadic Way of Life of the Population of Mongolia). *Salskie Khovelsvo Mongolii* [Ulaanbaatar]: 49-56. Originally published in *Sovremini Mongolii* 2 (15): 49-57;
5. Сталин, И.В. “Головокружениеотуспехов: К вопросамколхозногод-вижения”, *Правда*, №60, Москва, 2 марта 1930 г.